



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 9/96

Дэлгэрхаан сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
өвлүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах хүсэлт гаргасан иргэн Д.Нарантуяа (СЛ68062007)-д түүний нөхөр Ц.Эрдэнэболдын амралт үйлчилгээний зориулалттай 1200 кв.м газар эзэмших эрхийн гэрчилгээг 44 жилийн хугацаатай өвлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулж, газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (Д.Нарантуяа)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн 55 дугаартай захирамжийн (Ц.Эрдэнэболд)-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Э.ТӨГӨЛДӨР